

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Цагдаагийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн дор дурдсан дор дурдсанаар өөрчөн найруулсугай:

“17 дугаар зүйл.Цагдаагийн албаны сургалт

17.1.Цагдаагийн албаны сургалт нь мэргэшүүлэх, ур чадвар хөгжүүлэх, албан тушаалын буюу ажлын байрны сургалтаас бүрдэнэ.

17.1.1.Цагдаагийн алба хаагчийн албан тушаалын онцлог, хариуцсан ажил, үндсэн чиг үүргийг гүйцэтгэхтэй холбоотой сургалтыг мэргэшүүлэх сургалт

17.1.2.Цагдаагийн алба хаагчийн хуульд заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, тусгай хэрэгсэл хэрэглэхэд зайлшгүй шаардлагатай мэдлэг дадал, ур чадварыг эзэмшүүлэх чиглэлээр зохион байгуулах сургалтыг ур чадвар хөгжүүлэх сургалт

17.1.3.Энэ хуулийн 17.1.1, 17.1.2-т зааснаас бусад сургалтыг албан тушаалын буюу ажлын байрны сургалт.

17.2.Цагдаагийн албанд анх томилогдох болон албан тушаал дэвших, өөрчлөгдөх тохиолдолд богино болон дунд хугацааны сургалтад хамруулна.

17.3.Энэ хуулийн 17.1.1-д заасан сургалтын хөтөлбөр, агуулга, журмыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

17.4.Цагдаагийн алба хаагчийг мэргэшүүлэх, ур чадвар хөгжүүлэх, албан тушаалын буюу ажлын байрны сургалт явуулах төвийг аймаг, нийслэлд бүсчлэн байгуулж болно.

17.5.Энэ хуулийн 17.1.4-т заасан төв нь албаны нохой ашиглах болон Галт зэвсгийн тухай хуулийн 10.4-т заасан гэрээт харуул хамгаалалтын сургалтын төлбөртэй зохион байгуулж болно.

17.6.Энэ хуулийн 17.5-д заасан сургалтын төлбөрийн хэмжээг дотоод хэргийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтооно.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны ... сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
Гарын үсэг

